



## “АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024..... оны 03 сарын 16 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АСБИ хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 26-ны өдрийн Баасан гаригт 11.00 цагт компанийн оффисын байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  1. Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах
  2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
  3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
  4. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг 2024 оны 03 сарын 21-ний өдөр, 2024 оны 04 сарын 05-ны өдөр тус тус Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасныг баримтлан олон нийтэд зарласугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зарлах хэвлэлийн эхийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 03 сарын 22-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасыг 3а, 3б дугаар хавсралтаар баталж, саналын хуудасыг хүлээж авах сүүлчийн өдрийг 2024 оны 04 сарын 11-ний өдрийн 18.00 цагаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Лхагвасүрэн, тооллогын комиссын даргаар М.Сугармаа, гишүүдээр Д.Энхжаргал, А.Намуунтуул нарыг тус тус томилсугай.



Д.ЛХАГВАСҮРЭН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“АСБИ” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 99805900
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 04 сарын 26-ны өдрийн 11.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 99805900
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 03 сарын 16 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 03 сарын 21 өдөр, 2024 оны 04 сарын 05 өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 04 сарын 11 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 03 сарын 23 өдөр
Хүргүүлсэн огноо:	2024 оны 03 сарын 19 өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Лхагвасүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: С.Сугармаа, А.Намуунтуул, Д.Энхжаргал
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
	..... ширхэг
	..... хуудас



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

АСБИ  
ХК

/Л.СҮМБАНД/

2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр